

УЛС ТӨР,
ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА

ЗҮҮН ӨМНӨД АЗИ ДАХЬ ТҮГШҮҮРТЭЙ БАЙДЛЫН НЭГ ГОЛОМТ

С. ДАШЦЭВЭЛ
Түүхийн ухааны дэд эрдэмтэн

Зүүн Өмнөд Ази Энэтхэг-Хятадын хойгийг ЗХУКН-ын XXVII их хурлын улс төрийн илтгэлд М. С. Горбачевын тэмдэглэсэнчлэн «Ази-д унтраагүй байгаа цэрэг дайны аюулын голомт»¹ -ын нэг гэж үзэх ул үндэстэй юм.

Тайландын нутагт орогнож буй Кхмерийн харгис бүлэглэл, БНХКАУ ын хилд үе үе цөмөрч энгийн номхон иргэдийг хэлмэгдүүлсээр байгаагийн улмаас сүүлийн долоон жилийн турш Кампучи-Тайландын хил дээр зарлаагүй дайн үргэлжилсээр байна. Кхмерийн харгис бүлэглэл нь 30 мянга орчим хүнтэй Пол потын бүлэг, 15 мянга орчим хүнтэй Сианукийн бүлэг, 5,5 мянга орчим хүнтэй Сон Санны бүлгээс бүрдэж байгаа бөгөөд үзэл зорилго ондоо эдгээр бүлэглэлийг империалист болон харгис хүчин 1982 онд «эвслийн засгийн газар» гэгчид хүчээр нэгтгэх Нородом Сианукаар толгойлуулсан билээ. Энэ үеэс БНКАУ-ын эсрэг Кхмерийн харгис хүчний бүлгийнхэний дайсагнасан ажил явууллага улам идэвхжсэн юм.

Кхмерийн харгис бүлэглэлийг дэлхийн империализм, олон улсын харгис хүчин юуны өмнө америкийн империализм, Хятадын эрх баригчид, Тайландын засаг захиргаа элдвээр тэтгэн дэмжсээр байна.

Америкийн империализмын гол зорилго нь Кампучи дахь үндэсний сэргэн мандал, нийгмийн дэвшлийг саатуулах, Зүүн өмнөд Азид тогтворгүй байдлыг хэвээр байлгах, болж өгвөл түүнийг улам даамжруулж, улс орнуудын дотоод хэрэгт оролцох боломжийг бий болгон тус бүс нутагт алдсан байр сууриа эргүүлэн олж авч бэхжүүлэхийг эрмэлзэж байгаад оршиж байна. Тэд юуны өмнө Тайландын вант улсыг БНКАУ-ын эсрэг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Вашингтоны албаны хүмүүс Тайландад байнга очиж, «Тайландын аюулгүй байдлыг хамтын хүчээр хамгаалах» гэгч сэдвийг олонтаа дурсах боллоо. Зөвхөн сүүлийн жил хагасын хугацаанд АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Ж. Шульц, Төрийн нарийн бичгийн даргын Зүүн Ази, Номхон далайн асуудал эрхэлсэн орлогч П. Вулфовиц, АНУ-ын Тагнуулын Төв газрын захирал В. Ж. Казей, АНУ-ын Цэргийн нисэх хүчний яамны сайд В. Орр, Энэтхэгийн болон Номхон далайн районы зэвсэгт хүчний командлагч, адмирал Рональд Хейз нар Тайландад удаа дараа очив.

Тайландад өгч байгаа АНУ-ын цэргийн тусламж жилээс жилд нэмэгдсээр байна. АНУ-аас Тайландад үзүүлж байгаа цэргийн тусламж 1983 онд 80 сая, 1984 онд 91 сая, 1985 онд 110 сая доллар болж өсөв.

Энэ тусламжийн үлэмжхэн хэсэг нь төрөл бүрийн танк, сөнөөгч бөмбөгдөгч онгоц, хуягт тээвэрлэгч бусад сүүлийн үеийн цэргийн техник байна. Үүний зэрэгцээ Америк-Тайландын хамтарсан хээрийн сургууль тогтмолжиж Энэтхэг-Хятадын хойгийн аюулгүй байдалд занал-

¹ ЗХУКН-ын Төв Хорооноос ЗХУКН-ын XXVII их хуралд оруулсан улс төрийн илтгэл, Үнэн» 1986 2. 26.

хийлсээр байна. 1985 оны зун Сиамын буланд хийсэн «Кобра Гоулд-85» хээрийн сургуульд америкийн 7400 усан цэрэг, тайландын 3000 гаруй цэрэг, мөн Америк, Тайландын байлдааны усан онгоц 37, сөнөөгч-бөмбөгдөгч онгоц 100 гаруй оролцсон ажээ.

Америкийн зэр зэвсгээр өвч зэвсэглэж, сургуулилсан Тайландын цэргүүд БНХАУ-ын хил дээр байнга өдөөн хатгаж, Кампучийн тосгон сууринг их буугаар буудаж, тэгснээрээ Пол потын зандалчдын ажил явууллагыг хөнгөвчилж байгаа билээ.

Үүнээс гадна АНУ, Тайландын Батлан хамгаалах Яам 1985 оны хавар «Онцгой тохиолдолд хэрэглэх зэвсэг хэрэгсэлийн агуулах бааз Тайландад байрлуулахаар тохиролцжээ. Гонконгын «Фар Естерн экономик ревью» сэтгүүлийн мэдээлж буйгаар 1984 оны 10-р сард Кхмерийн харгис бүлэглэлд өгөх тусламжийг хуваарилах тусгай комиссыг Тайланд, Сингапур, Малайз, АНУ-ын төлөөлөгчдийг оролцуулан Тайландад байгуулсан байна. Мөн «Кампучийн асуудлыг зохицуулах бүлэг» нэртэй АНУ-ын тагнуулын Төв газрын хяналт хараан дор байдаг байгууллага хилийн ойролцоо байгаа ажээ.

БНКАУ-ын эсрэг чиглэсэн Кхмерийн харгис бүлэглэлийг дэмжиж цэрэг-санхүүгийн тусламж үзүүлж байгаагаа АНУ элдвээр нуун далалахыг хичээж байгаа боловч эдүгээ нийтэд илэрхий болжээ.

Кхмерийн харгис бүлэглэлд үзүүлж буй АНУ-ын тусламжийг албан ёсны буюу засгийн газрын шугамаар өгч буй тусламж, тагнуулын төв газрын шугамаар өгч буй тусламж, мөн олон улсын тусламжийн хүрээнд илгээж буй тусламж хэмээн наад зах нь гурав ангилж болох бөгөөд гол нь Сон Санны болон Сианукийн бүлэгт Вашингтоны тусламж очиж байна. Зөвхөн олон улсын байгууллагын шугамаар Кампучи-Тайландын хил дээрх «дүрвэгчидэд туслах» нэрээр 1984 онд Вашингтон 15 сая долларын тусламж нийлүүлжээ.² АНУ-ын албаны хүмүүс сүүлийн үед Тайланд, Кампучийн хил дээр нэг бус удаа очиж, Кхмерийн харгис бүлэглэлийн толгойлогчидтой уулзсан билээ. 1985 онд Вашингтоныхон хэд хэдэн удаа ийнхүү аялсаны дараа Кхмерийн харгис бүлэглэлд үзүүлэх тусламжаа нэмэхээр шийджээ. Мөн Сон Санн, Нородом Ранаридхи тэргүүтэй Кхмерийн харгис бүлэглэлийн төлөөлөгчид 1985 онд Вашингтонд айлчлах үеэр АНУ-ын зүгээс нэмэлт тусламж амлажээ.

Хятадын эрх баригчидын хувьд Кхмерийн харгис бүлэглэлүүдийг доторхи гол хүчин болсон Пол Потын бүлэгт зэвсэг хүнс байнга нийлүүлж байна. Гадаадын хэвлэлийн мэдээгээр хятадын зүгээс Кхмерийн харгис бүлэглэлд өгч байгаа цэргийн бүх тусламжийн 95 хувь нь Пол потын бүлэгт очиж байгаа бөгөөд тэгснээрээ Пол потын бүлгийг гол шийдвэрлэгч хүчин хэвээр байлгахыг чармайж байгаа ажээ. Пол потын бүлэглэлд үзүүлж байгаа Хятадын тусламж жилээс жилд нэмэгдэж байна. 1983 онд 10 мянган доллар, цэргийн бусад зэвсэг хэрэгсэл нийлүүлсэн бол 1984 онд 1,2 сая долларын тусламж, 1985 онд түүнээс хоёр дахин их тусламж өгчээ. Кхмерийн харгис бүлэглэлд винтов АК-47, автомат «Мерсер», мин, гранат, цэргийн бусад хэрэгслийг нийлүүлж байгаагаас гадна хувцас, хүнсээр хангаж байна.

Тайланд дахь Хятадын Элчин сайдын Яам үлэмжхэн үүрэг гүйцэтгэж байгаа ажээ. Пол потын үед Пномпенд элчин сайдаар сууж байсан Сун Хао, цэргийн атташе агсан Дэн Суншан, хангамжийн ажил эрхэл-

² La guerre non declaree contre la Republique populaire du Kampuchea, 1985 Pnompenh, p. 48.

сэн Ван Маоцин нар Тайландад сууж Пол потын цэрэгт тусламж дамжуулах, байлдааны болон тагнуулын сургууль хийлгэх, хил дээр өдөөн хатгаж хорлон сүйтгэх ажиллагаа явуулахад биечлэн тусалж байна. Гадаадын хэвлэлийн мэдээгээр Тайланд дахь Пол потын цэрэгт байлдаанн бэлтгэл хийлгэж байгаа хятад сургагч, мэргэжилтэн нарын тоо 20 мянга орчим байгаа ажээ.³ Хилийн орчмоор бүгсэн Кхмерийн харгис бүлэглэлийн улс төрийн курс гэгчид Хятадын мэргэжилтнүүд байнга хичээл заадаг тухай Кхмерийн харгис бүлгээс оргон ирэгсэд мэдүүлж байна.

Хятадын эрх баригчид «Кампучийн асуудлыг» өөртөө ашигтайгаар шийдвэрлэхэд Пол потын бүлгийн зэвсэгт өдөөн хатгалгыг гол даралт шахалт болгон ашиглахыг эрмэлзэж байна. Тэдний үзэж буйгаар Вьетнамын цэрэг кампучид байгаа нөхцөлд «Кампучийн асуудлыг» шийдвэрлэх нь цэрэг зэвсгийн хүчээр шийдвэрлэж байгаа хэрэг бөгөөд Вьетнамын цэргийг Кампучаас гаргахын тулд Камерийн харгис бүлэглэл, түүний дотор гол нь Пол Потын бүлгийн зэвсэгт тэмцлийг улам хүчтэй болгох хэрэгтэй ажээ. Энэ үүднээс Кампучийн эсрэг Кхмерийн бүлгийн Зэвсэгт өдөөн хатгалгыг бүх талаар дэмжиж байна.

Чингэснээр социалист нөхөрлөлийн орнуудыг холбоотноо болгох нийгэм-эдийн засгийн дэвшилт өөрчлөлт хийж байгаа шинэ залуу Кампучи улсын засаг төрийг унагааж, оронд нь Пол потын харгис дэглэмийг сэргээх зорилготой нь илэрхий билээ. Үүний зэрэгцээ сүүлийн 7 жилийн турш Хятадын эрх баригчид Кампучийн үндэсний ардын ардчилсан хувьсгал буюу Кампучи дахь хэрэг явдлын мөн чанарыг мушгин гуйвуулсан суртал нэвтрүүлгийн өргөн кампани дэгдээж байгаа нь ЗХУ, БНСВУ-ын нэр хүндийг дэлхийн тавцанд бууруулахад чиглэгдэж байгаагаас гадна БНСВУ-ыг Зүүн өмнөд Азийн бусад орнуудаас хөндийрүүлэх, АНУ болон империалист бусад хүчинд тал засах зэрэг хэд хэдэн зорилготой бололтой.

АНУ, Хятад хоёрын аль аль нь БНКАУ-ыг шууд дайсагнаж засаг төрийг нь өөрчлөх, кампучийн хэрэг явдлаар далимдуулан тэр бүс нутагт өөр өөрийн байр суурийг бэхжүүлэх эрмэлзлэлтэй байгаагаараа зорилго, байр суурь нь ойр байна. Тэгэхдээ Хятадын эрх баригчид Пол потын талынханд гол найдлага тавьж, түүний хувь заяаг голлон анхаарч Хятадын талыг барьсан засаглал хэзээ нэг цагт тогтоохыг эрмэлзэж байхад АНУ Пол потынхноос болгоомжилж, Сон Санны болон Сианукийн бүлэгт найдлага тавин Кампучийг социалист ертөнцийн талд биш капиталист системд байлгаж, нийгмийн дэвшлийг нь саатуулахыг эрмэлзэх: байгаагаараа ялгаатай байна.

АНУ, Хятад хоёрын аль аль нь АСЕАН-ы орнуудыг Энэтхэг-Хятадын гурван орны эсрэг хандуулах эрмэлзлэлтэй байна. Үүнд АСЕАН-ы орнууд капиталист хөгжлийн замаар хөгжиж, засаг төрийн эрх баригчид нь үндсэндээ коммунизмын эсрэг үзлийг баримталж байгаа байдлыг АНУ овжин ашиглаж, БНКАУ-ын эсрэг дайсагнасан ажиллагаандаа аль болохоор татан оруулахыг мэрийж байна. Гэвч АСЕАН-ны орнуудын дотор бүс нутгийн бүх орнуудын харилцааг хэвийн болгож, энх тайван тогтвортой байдлыг сэргээх гэсэн хандлага улам бүр хүчтэй болж байна. Үүнд Индонез, Малайзийн засгийн газар сүүлийн жилүүдэд бусдаасаа илүү хүчин чармайлт гаргаж байгаа юм. Харин Кампучитай хил залгаа оршдог Тайландын хувьд нэлээд сөрөг бодлого баримталсан хэвээр байна.

³ Вьетнам No 1, 1984.

Тэд нутаг дэвсгэр дээрээ Кхмерийн харгис хүчний бүлэглэлүүдийг орогнуулж, АНУ, Хятад болон бусад орнуудын тусламжийг дамжуулах, БНХАУ-ын эсрэг өдөөн хатгаж, зарим үед их буу, нисэх онгоц хүртэл хэрэглэж байна. 1980 оноос хойш Кампучи улсын агаарын хилийг жилд дундаар 700 гаруй удаа, хуурай газрын хилийг 3000 гаруй удаа, усан хилийг 4700 гаруй удаа тус тус зөрчиж, сүүлийн үед агаарын хил зөрчих нь улам бүр нэмэгдсээр байгааг БНКАУ-ын Гадаад явдлын Яамнаас саяхан нийтлүүлсэн цагаан номонд дурджээ⁴. Индонез, Малайзын засгийн газар хятадын аюул заналаас гол нь болгоомжилж, Хятад-Америкийн харилцаа цэргийн салбарт гүнзгийрч буйн улмаас Хятадын цэргийн потенциал нэмэгдэх байгаад сэтгэл түгшиж Хятадын аюул занал бодитой байгааг хүлээн зөвшөөрч байхад Тайландын эрх баригчид Вьетнамыг Энэтхэг-Хятадын хойг болон Тайландад гол аюул занал учруулагч хэмээн үзэж байгаа юм. Үүгээрээ Тайландын байр суурь, АНУ, Хятадын байр суурьтай адил байна.

Сүүлийн жилүүдэд Тайланд, Хятадын эрх баригчид цэргийн төлөөлөгчөө байнга солилцож Кампучи-Тайланд, Хятад-Вьетнамын хил дээрх цэрэг дайныхаа ажиллагааг уялдуулсаар байна.

Хэдийгээр Кхмерийн харгис бүлэглэлүүд БНКАУ-ын эсрэг дайсагнасан ажиллагаандаа империализм, харгис хүчний тусламж дэмжлэгийг тасралтгүй авч байгаа ч гэсэн тэдний санаархал бүтэмж муутай байна.

Тухайлбал 1985 оны хуурай улиралд Кампучийн Ардын хувьсгалт арми, Вьетнамын сайн дурын цэргийн тусламжтайгаар Кампучи-Тайландын хилийн дагуу бүгсэн харгис бүлэглэлийн бүх баазуудыг устгаж, 10 мянга гаруй дээрэмчдийг жагсаалаас гарган олон мянган тонн зэр зэвсгийг олзолжээ.

Кхмерийн харгис бүлгийнхэний сэтгэл санаа улам бүр унаж, тэднээс «чөлөөлөх дайн» гэгчийнхээ учир утгагүй, ирээдүйгүй байдлыг ойлгож, зэвсгээ хаян ардын засгийнханы талд ирэгсэдийн тоо нэмэгдсээр байна. Зөвхөн 1985 оны эхний хагаст арван мянга гаруй хүн БНКАУ-ын талд иржээ.⁵ Кхмерийн харгис бүлэглэлийн эв түнжин ч сайжирсангүй, ан цав нь гүнзгийрсээр байна. Бие биенийгээ үзэн ядаж гал нээн алалцах, нэг бүлэг нь нөгөө бүлээ тонон дээрэмдэх нь ерийн хэрэг болжээ. Пол потынхны 470-р нууц тогтоол ёсоор бол Сон Санны бүлгийнхнийг нууцаар, ул мөр үлдээлгүй хорлон сүйтгэх, алж талах явдлыг өөгшүүлэн дэмжсэн байдаг ажээ.⁶

Кампучи, Тайландын хил дээрх түгшүүртэй байдлын шалтгаан, Энэтхэг-Хятадын хойг, ЗӨА-ийн энх тайван, аюулгүй байдлыг занал хийлж буй уг сурвалк бол БНКАУ-ын эсрэг явуулж байгаа империалист болон бусад харгис хүчний тасралтгүй явуулж буй хагалан бутаргах явууллага гэдэг нь хэн бүхэнд тодорхой байна.

Кхмерийн харгис хүчний бүлэглэлүүд дампууралд орох тусам уг бүлэглэлийг дэмжигчид, ялангуяа Бээжингийнхэн гурван бүлэглэлийг «эв нэгдэлтэй» гэж дэлхийн олон нийтэд харуулахыг мэрийж, тэдний тэмцэл улам амжилт олж байгаа мэтээр сурталчилж байна.

Зүүн Өмнөд Азийн аюулгүй байдлын тулгамдсан чухал асуудлын нэг нь Кампучи, Тайландын хилийн аюулгүй байдлыг хангах, тэнд тасрахгүй байгаа буун дууг зогсоох явдал билээ. Энэ талаар Энэтхэг-Хятадын хойгийн гурван орон өөрөөсөө хамаарах бүхнийг хийж ирэв.

⁴ La guerre non declaree contre la Republique populoire du Kampuchea, 1985, 38.

⁵ «Правда» 1985. 11. 16.

⁶ Мөн тэнд

Үүний нэг тод илрэл нь бүр 1980 онд Кампучийн засгийн газар хилийн аюулгүй байдлыг хангах талаар Тайландад хандаж харилцан үл довтолох, бие биеийн дотоод хэрэгт үл оролцох, нутаг дэвсгэрээ бусад орны дайсагнагч хүчинд үл ашиглуулах тухай хэлэлцээр хийх саналыг дэвшүүлсэн явдал юм. Үүний зэрэгцээ Кампучи, Тайландын хилийг энх тайван найрамдлын хил болгох тухай 4 зүйлт санал дэвшүүлэв. Энэ санал ёсоор хоёр улсын хилийн районд цэрэггүй бүс байгуулах санал дэвшүүлсэн боловч Тайландын тал хил орчмын нутгийнхаа бүрэн эрхийг алдах болзошгүй хэмээн сэжиглэж, үл зөвшөөрсөн учир 1982 онд хоёр улсын хил орчмоор аюулгүй бүс байгуулах шинэ санал дэвшүүлсэн юм⁷. Тухайлбал Кампучи, Тайландын хилийн дагуу аюулгүйн бүс байгуулах, Үүний тулд кампучийн талын цэрэггүй бүсээс Вьетнамын цэргийг гаргаж Зөвхөн Кампучийн цэргийг үлдээх, Тайландын талын бүст зөвхөн Тайландын цэргийг үлдээж, Кхмерийн харгис бүлэглэлүүд болон дүрвэгсэдийг үл байлгах санал дэвшүүлсэн билээ⁸.

1985 оны 8-р сард Энэтхэг-Хятадын хойгийн 3 орон, бие биеийн дотоод хэрэгт үл оролцох, тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн байдлыг харилцан хүндэтгэх, бусад орны аюулгүй байдлын эсрэг газар нутгаа үл ашиглуулах, энх тайвнаар зэрэгцэн орших зарчмын үндсэн дээр Тайландтай хэлэлцээр хийхэд бэлэн байгаагаа мэдэгдсэн байна⁹.

Тайландын эрх баригчид эдгээр бүх санал, санаачлагыг нааштай хүлээн авахгүй байна. Тэд Тайландад социализмын нөлөө нэвтрэхээс болгоомжлохын хамт Тайланд, Кампучийн хилийн түгшүүртэй байдлаар далимдуулж империалист хүчний туслалцааг авч батлан хамгаалах хүчин чадлаа зузаатгахыг эрмэлзэж байгаагаас БНКАУ-ын эсрэг харгис хүчний явууллагад ийнхүү татагдан орж байна.

Хятад, Тайланд болон бусад сөрөг хүчин Кампучитай холбогдсон бүх асуудлыг авч үзэхдээ юуны өмнө Кампучаас Вьетнамын цэргийг бүрэн гаргах шаарлага тавьж байгаа юм.

БНКАУ-ын эсрэг дайсагнасан ажил үйлдэж байгаа Пол потын бүлэглэлийг Хятадын зүгээс дэмжсээр байгаа нөхцөлд Кампучаас цэргээ бүрэн гаргах нь Хятадын ажил явууллагыг чөлөөтэй болгож, Пол потын дэглэмийг сэргээх боломж олгоно гэж Энэтхэг-Хятадын хойгийн орнууд үзэж байна. Тийм ч учраас Хятадын зүгээс Пол Потын болон бусад харгис бүлэглэлийг ашиглан Энэтхэг-Хятадын хойгийн улс орнуудад түүний дотор Кампучид, заналхийлэхээ больж, Пол потын бүлгийг цэрэг, улс төрийн хувьд устгамагц өөрийн бүх цэргийг Кампучиас нэн даруй татан гаргахад бэлэн байна гэдгээ БНСВУ-ын засгийн газар нэг бус удаа мэдэгдсэн билээ.

Энэтхэг-Хятадын хойгийн гурван орон ЗӨА-ийн энх тайван, тогтвортой байдлын бүс болгохын тулд юуны өмнө АСЕАН-ы орнуудтай энх тайвнаар зэрэгцэн орших бодлогыг хэрэгжүүлэхийг эрмэлзэж, ЗӨА-ийн маргаантай бүх асуудал, түүний дотор «Кампучийн асуудлыг» эрх тэгш, харилцан бие биеэ хүндэтгэх зарчимд тулгуурлан шийдвэрлэхийг эрмэлзэж байна. Үүний тулд бүс нутгийн буюу эсвэл олон улсын бага хурал хийх санал тавьсан билээ. Бүс нутгийн бага хурлыг АСЕАН-ыг орнууд болон Энэтхэг-Хятадын хойгийн гурван орны хүрээнд эсвэл эл хоёр бүлэг улсыг төлөөлсөн хоёр этгээдийн хооронд хийж болох юм гэж

⁷ «Нянзан», 1985. 8. 23.

⁸ Le courrier du Vietnam, 1982. N 8, p. 3.

⁹ «Нянзан», 1980.8.23.

*1982 оноос БНСВУ-ын засгийн газар өөрийн цэргийг Кампучиас дөрвөн удаа гаргасан нь нийт сайн дурынханы гуравны нэг болж байна.

үзэж байна. Хэлэлцэх асуудлын хувьд бол ЗӨА-ийг энх тайван, тогтвортой байдлын бүс болгох асуудлыг Кампучитай холбогдсон асуудалтай нягт холбоотой үзэж, Кампучийн ард түмний бие даан тохинох эрхийг юуны өмнө хүйс тэмтрэн устгагч дэглэмийн аюул заналгүйгээр улс орноо сэргээн хөгжүүлэх эрхийг хүндэтгэх, нийгмийн өөр өөр байгуулалтай улсууд энх тайвнаар зэрэгцэн орших, тус тусын нутаг дэвсгэрийг өөр улсын эсрэг ашиглуулахгүй байх, бусад орнууд ЗӨА-ийн орнуудын бүрэн эрхийг хүндэтгэх үндсэн дээр хэлэлцэн шийдэж болох юм¹⁰ гэж үзэл байна.

АСЕАН-ы орнууд «Кампучийн асуудлыг» улс төрийн аргаар шийдэхэд санал нэгтэй байгаа ч гэсэн Кампучийн одоогийн хууль ёсны засгийн газрын эрх ашгийг хохироох замаар шийдэхийг эрмэлзсэн хэвээр байгаа учраас асуудлыг цогцолбороор шийдэхэд бэрхшээлтэй хэвээр байна.

Харин АСЕАН-ы орнуудын ихэнх нь бүс нутгийн орнуудын харилцаанд «Кампучийн асуудал» бул чулуу болох ёсгүй хэмээн үзэж, Кампучитай холбогдсон асуудлыг хойш тавиад Вьетнам, Лаостай сайн хөршийн харилцааг сэргээх сонирхолтой байна. Энэ нь бүс нутгийн түгшүүртэй байдлын голомтыг арилгахад учир дутагдалтай боловч ЗӨА-ийн хоёр бүлэг улсын хооронд бие биенээ ойлгох, итгэлцэх уур амьсгал өргөжин тэлсээр байгаагийн нэг илрэл төдийгүй, ЗӨА-ийн энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэхэд ямар ч гэсэн нааштай уур амьсгал мөн билээ.

Энэ үндсэн дээр сүүлийн үед Энэтхэг-Хятадын хойгийн орнууд болон АСЕАН-ы орнуудын хооронд янз бүрийн шугамаар уулзалт яриа болсоор байна. ЗӨА-ийн хоёр бүлэг улсыг төлөөлөн БНСВУ, Индонезийн хооронд Гадаалд явлын Яамны орлогч сайдын хэмжээнд уулзалт болж байгаа нь Зүүн Өмнөд Азийг энх тайван тогтвортой байдлын бүс болгох үзэл санаа хэрэгжихэд нааштай алхам болж байна. Энэ уулзалт «Кампучийн асуудлын» шудрагаар зохицуулах арга замыг сүвэгчилэхэд ч ямар нэг хэмжээгээр хувь нэмэр болж магад хэмээн бүс нутгийн олон нийт хүлээж байна. Нөгөө талаар БНКАУ-ын эдийн засаг, батлан хамгаалах хүчин чадал улам бүр бэхжиж, Вьетнамын сайн дурын цэргүүдийн үлэмж хэсэг нь камгучаас гарах бололцоо нэмэгдсээр байгаа нь «Кампучийн асуудал» аяндаа үгүй болох хэтийн төлөв нээж байна. Кампучийн дотоод байдал бэхжихийн хэрээр тус улсаас цэргээ хойшид ч гаргана гэдгээ Вьетнамын засгийн газар нэгэнт мэдэгдсэнийг үүнтэй холбогдуулан дурдахад илүүдэхгүй.

Хэрвээ Вьетнамын сайн дурын цэргүүд Кампучаас ийнхүү гарчихвал сөрөг талынхан, юуны өмнө Хятад, Тайланд хэлэлцээний ширээнд суухаас татгалзах бодит шалтгаан үгүй болно. Тэгэхдээ хятадын эрх баригчид Кампучи улс сэргэн мандаж, бэхжихийн эсрэг бүхий л арга хэрэглэж байгааг мартаж болохгүй юм.

Тайландын хувьд бол хил залгаа орнуудтайгаа удтал дайсагналцах нь эдийн засагт нь нөлөөлж, дотоод улс төрийн хямралд хүргэх, бүс нутгийн олонхийн дургүйцэлтэй тулгарч мэдэх учир одоогийн сөрөг байр сууриа удаан хадгалах чадахгүй гэж үзэх үндэс байна.

Харин өнөөгийн дэлхийн империализмын дайнч түрэмгий бодлого гаарч олон улсын уур амьсгал хурцадмал болж байгаа байдал хийгээд, Ази, Номхон далайн районыг Вашингтоныхон үлэмжхэн шохоорхох болсон зэргийг харгалзан үзвэл ЗӨА-ийн энэ бүс нутгийн сөрөг хандлагад

¹⁰ Нянзан. 1985.1.19

АНУ-ын хүчин зүйл үлэмжхэн нөлөөлөх мэт боловч одоогийн байдлаар ЗӨА дахь улс орнуудын ихэнх нь бүс нутгийн бие даасан хөгжлийг чухалчлан анхаарч, байгаа учир тус бүс нутаг дахь АНУ-ын шууд оролцоог тодорхой хэмжээгээр хязгаарлаж байна. Энэ нь Кампучийн асуудалд ч хамаарч байгаа юм.

Энэ бүхнээс дүгнэж үзвэл Кампучийн эсрэг, ЗӨА-ийн аюулгүй байдлын эсрэг империализм, харгис хүчин дайсагнасан ажлаа үргэлж дүүлсээр байгаа бөгөөд зарим тохиолдолд улам ч идэвхижүүлж байна. Гэвч тус бүс нутаг дахь түгшүүртэй байдлын голомтыг арилгаж, энх тайван, тогтвортой байдлыг бэхжүүлэх бодит үндэс суурь байсаар байна. Энэ бололцоог бодит зүйл болгоход

- Империалист хүчний түрэмгий санаархлыг хазаарлан барьж байгаа дэлхийн социализм, энхийг эрхэмлэгч бүх хүчний идэвхитэй хүчин чармайлт, түүний үр нөлөөний өсөлт;

-Энэтхэг-Хятадын хойгийн улс орнуудын дотоод байдал, олон улсын байр суурийн бэхжилт;

- ЗӨА-ийн энх тайван, тогтвортой байдлын бүс болгох гэсэн бүс нутгийнханы нэгдсэн чармайлт, түүний дотор бүс нутгийн улс орнуудын үр ашигтай уулзалт, яриа, хэлэлцээ;

-Бүс нутгийн эрх ашигт бүрэн нийцсэн Энэтхэг-Хятадын хойгийн гурван орны энх тайванч хүчин чармайлт, бүтээлч санаачлагууд;

-Хятадын эрх баригчдаас олон улсын өнөөгийн байдалд болон «Кампучийн асуудалд» цаашид ангич байр сууринаас хандах эсэх гэх мэт хэд хэдэн хүчин зүйл нөлөөлөх болно.

Үүнийг Монголын олон нийт гүнээ ухамсарлаж, Ази, Номхон далайн улсуудын хооронд харилцан үл довтолох, хүч үл хэрэглэх конвенц байгуулах санаачлага гарган, түүнийг хэрэгжүүлэхийн төлөө хийж буй үйл ажиллагаагаараа ах дүү гурван орны хүчин чармайлтад ч тус дөхөм үзүүлэх чин эрмэлзлэлтэй байна.